



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.04.10 № 1/1417  
танай 2024.04.10-ны № ХЭГ/706-Т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Б.ЭНХБАЯР

151601298  
Doc.yam a5.2024



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД


Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.04.10 № 01/2470  
танай 2024.04.10-ны № ХЗГ/207-Т

### МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй байгаль, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

9761000946



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

Хуулийн төсөл нэн яаралтай  
хэлэлцүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцэх асуудлын тов, дарааллыг харгалзахгүйгээр Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлсүгэй.

2. Энэ захирамжийн 1 дэх заалтад заасан хуулийн төслийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо (Ж.Батжаргал)-нд даалгасугай.

ДАРГА



Г.ЗАНДАНШАТАР





МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГА ГОМБОЖАВЫН  
ЗАНДАНШАТАР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.04.10 № 3Г-1/42

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
тухай

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.04.10 № ХЭТ/705  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Д.ЭНХБАТ ТАНАА

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацаа товлох тухай**

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 12 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА




Д.АМАРБАЯСГАЛАН

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны 14 дүгээр тэмдэглэлд:

“2.ХЭЛЭЛЦСЭН нь: Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдийн гаргасан саналыг тусган Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР